



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/188/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn Ахлах аудитор: Н.Бадамхатан Утас: 325093 Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn Аудитор: М.Нарангэрэл Утас: 325093 Цахим хаяг: narangerelm@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 382
танай _____-ны № _____-Т

НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР
ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Ц.ОСОРВААНЬ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

D:\Desktop\2024\Word\Report\2024.02.23.88D.171.docx
002021779

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 98.0 хувийн хэрэгжилттэйгээр гүйцэтгэн, тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.Аудит хийсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Эргэлтийн хөрөнгө	<u>971,480,063.45</u>	<u>549,068,223.20</u>
33	Авлага	<u>703,245,099.28</u>	<u>64,588,469.04</u>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	619,436,400.00	-
335	Бусад авлага	<u>83,808,699.28</u>	<u>64,588,469.04</u>
3351	Байгууллагаас авах авлага	69,802,525.28	64,588,469.04
3352	Хувь хүмүүсээс авах авлага	14,006,174.00	-
34	Урьдчилгаа	<u>130,680,328.15</u>	<u>219,214,228.15</u>
34600	Урьдчилж гарсан зардал	130,680,328.15	219,214,228.15
35	Бараа материал	<u>137,554,636.02</u>	<u>265,265,526.01</u>
351	Түүхий эд материал	<u>701,000.00</u>	<u>701,000.00</u>
35110	Тусгай зориулалттай материал	701,000.00	701,000.00
354	Хангамжийн материал	<u>136,853,636.02</u>	<u>264,564,526.01</u>
35410	Бичиг хэргийн материал	8,867,210.00	10,950,900.00
35420	Аж ахуйн материал	45,066,451.01	54,777,151.01
35430	Сэлбэг хэрэгсэл	12,224,000.00	16,634,300.00
35440	Түлш, шатах тослох материал	3,096,000.01	-
35470	Бусад хангамжийн материал	67,599,975.00	182,202,175.00
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>239,757,734.16</u>	<u>337,549,884.13</u>
39	Үндсэн хөрөнгө	<u>239,757,734.16</u>	<u>337,549,884.13</u>
392	Биет хөрөнгө	<u>229,958,125.82</u>	<u>332,661,642.38</u>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	134,500,000.00	134,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(50,218,750.00)	(61,843,750.00)
39205	Машин тоног төхөөрөмж	217,678,146.10	383,051,061.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(124,904,595.76)	(167,038,328.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	112,728,611.04	113,718,611.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	(59,825,285.56)	(69,725,951.38)
393	Биет бус хөрөнгө	<u>9,799,608.34</u>	<u>4,888,241.75</u>
39301	Программ хангамж	9,814,400.00	9,814,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(14,791.66)	(4,926,158.25)
3	Нийт хөрөнгийн дүн III=I+II	<u>1,211,237,797.61</u>	<u>886,618,107.33</u>
4	Нийт өр төлбөр	<u>21,579,429.27</u>	<u>35,628,729.27</u>
41	Богино хугацаат өр төлбөр	<u>21,579,429.27</u>	<u>35,628,729.27</u>
413	Өглөг	<u>21,579,429.27</u>	<u>35,628,729.27</u>
4136	Бусад өглөг	<u>21,579,429.27</u>	<u>35,628,729.27</u>
41361	Байгууллагад төлөх өглөг	21,579,429.27	35,628,729.27
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>1,189,658,368.34</u>	<u>850,989,378.06</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>1,189,658,368.34</u>	<u>850,989,378.06</u>
511	Засгийн газрын оруулсан капитал	44,964,769.50	44,964,769.50
51101	Өмч: - төрийн	44,964,769.50	44,964,769.50
512	Хуримтлагдсан үр дүн	<u>1,143,403,254.09</u>	<u>804,734,263.81</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,143,403,254.09	1,143,403,254.09
51220	Тайлант үеийн үр дүн	-	(338,668,990.28)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,290,344.75	1,290,344.75
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн VI=IV+V	<u>1,211,237,797.61</u>	<u>886,618,107.33</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үйл ажиллагааны орлогын дүн (I)	6,648,013,220.00	7,533,374,255.90
12	Татварын бус орлого	19,837,000.00	4,851,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	19,837,000.00	4,851,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,837,000.00	4,851,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	4,851,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,697,000.00	-
13	Тусламж, санхүүжилтийн орлого	6,628,176,220.00	7,528,523,255.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,373,108,120.00	1,445,402,290.00
131104	ДШ-ныТЗ-ийн төсвөөс доод шатны ТЗ-д хуваарилсан хөрөнгө	2,373,108,120.00	790,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн ү/а-ны нэмэлт орлого	-	654,902,290.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,255,068,100.00	6,083,120,965.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /ОНТБ/	4,255,068,100.00	6,083,120,965.90
2	Үйл ажиллагааны зардлын дүн	6,608,675,630.91	7,872,043,246.18
21	Урсгал зардал	6,608,675,630.91	7,872,043,246.18
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	4,336,443,963.81	6,337,666,424.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,007,614,775.68	1,279,559,025.88
210101	Үндсэн цалин	644,808,449.65	744,891,987.01
210102	Нэмэгдэл	97,034,900.27	190,979,993.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	132,785,000.00	211,624,939.66
210104	Урамшуулал	65,952,672.95	70,774,295.36
210105	Гэрээт ажлын хөлс	67,033,752.81	61,287,810.03
2102	АО-с нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,232,429.65	160,879,868.99
210201	Тэтгэврийн даатгал	93,606,458.15	110,498,142.85
210202	Тэтгэмжийн даатгал	9,903,032.77	12,993,634.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,841,786.42	10,289,307.73
210204	Ажилгүйдлийн даатгал	1,671,486.81	2,332,625.39
210205	Эрүүл мэндийн даатгал	19,209,665.50	24,766,158.95
2104	Хангамж, бараа материалын зардал	99,982,049.86	140,157,706.19
210401	Бичиг хэрэг	23,536,983.00	26,671,070.00
210402	Тээвэр, шатахуун	58,382,339.99	70,575,500.01
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,681,060.54	3,645,772.26
210404	Ном, хэвлэл	4,207,500.00	34,975,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,174,166.33	4,290,363.92
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,479,700.00	3,332,000.00
210604	Урсгал засвар	1,479,700.00	3,332,000.00
2107	Томилолт, зочны зардал	213,420,830.00	569,274,840.81
210701	Гадаад албан томилолт	191,658,430.00	457,353,699.81
210702	Дотоод албан томилолт	4,862,400.00	25,686,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	16,900,000.00	86,235,141.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ төлбөр	2,694,795,918.33	4,002,271,973.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажлын төлбөр	2,694,795,918.33	4,002,271,973.08
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	186,918,260.29	182,191,010.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,323,240.00	95,084,165.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	67,367,000.00	18,536,080.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	107,228,020.29	68,570,765.03
213	Урсгал шилжүүлэг	2,272,231,667.10	1,534,376,821.20
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	33,000,000.00	34,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	33,000,000.00	34,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,562,141,064.83	844,519,334.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	983,600,000.00	607,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	578,541,064.83	236,819,334.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	677,090,602.27	655,857,487.20
3	Үйл ажиллагааны үр дүн (3)=(1)-(2)	39,337,589.09	(338,668,990.28)
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
4	Үйл ажиллагааны бус үр дүн (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	39,337,589.09	(338,668,990.28)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн (1)	6,628,316,220.00	8,152,810,655.90
12	Татварын бус орлого	140,000.00	4,851,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	140,000.00	4,851,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	140,000.00	4,851,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	4,851,000.00
13	Тусламж, санхүүжилтийн орлого	6,628,176,220.00	8,147,959,655.90
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	-	619,436,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,004,436,400.00	1,445,402,290.00
131104	ДШ-ны ТЗ-ийн төсвөөс доод шатны ТЗ-д хуваарилсан хөрөнгө	1,385,000,000.00	790,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн ү/а-ны нэмэлт орлого	619,436,400.00	654,902,290.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,458,739,820.00	6,083,120,965.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /ОНТБ/	4,255,068,100.00	6,083,120,965.90
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	203,671,720.00	-
1330	Төсвийн захирагчдаас	165,000,000.00	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	165,000,000.00	-
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн (2)	6,617,746,820.00	7,986,447,740.90
21	Урсгал зардал	6,617,746,820.00	7,986,447,740.90
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	4,342,315,152.90	6,443,995,979.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,007,865,136.58	1,273,174,781.84
210101	Үндсэн цалин	587,077,655.32	731,403,024.19
210102	Нэмэгдэл	96,776,574.56	190,979,993.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	147,366,860.03	218,729,658.44
210104	Урамшуулал	110,361,701.15	70,774,295.36
210105	Гэрээт ажлын хөлс	66,282,345.52	61,287,810.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,232,429.65	160,877,668.99
210201	Тэтгэврийн даатгал	93,606,458.15	124,331,956.30
210202	Тэтгэмжийн даатгал	9,903,032.77	12,609,092.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,841,786.42	3,171,025.39
210204	Ажилгүйдлийн даатгал	1,671,486.81	8,562,714.74
210205	Эрүүл мэндийн даатгал	19,209,665.50	12,202,879.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	23,933,445.00
210304	Байрны түрээс	-	23,933,445.00
2104	Хангамж, бараа материалын зардал	90,853,592.54	205,702,482.26
210401	Бичиг хэрэг	22,973,290.00	27,436,660.00
210402	Тээвэр, шатахуун	16,166,700.00	12,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,589,470.54	4,170,172.26
210404	Ном, хэвлэл	20,000,000.00	145,679,330.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,124,132.00	16,416,320.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,705,440.00	22,737,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,500,000.00	14,039,100.00
210604	Урсгал засвар	5,205,440.00	8,698,800.00
2107	Томилолт, зочны зардал	265,087,317.00	544,834,541.87
210701	Гадаад албан томилолт	249,016,917.00	424,692,448.87
210702	Дотоод албан томилолт	6,070,400.00	26,686,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10,000,000.00	93,456,093.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,718,779,097.13	3,859,146,439.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажлын төлбөр	2,711,638,597.13	3,856,902,829.80
210803	Даатгалын үйлчилгээ	-	1,471,110.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,140,500.00	772,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,792,140.00	353,588,720.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,025,140.00	293,088,720.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	94,767,000.00	60,500,000.00
213	Урсгал шилжүүлэг	2,275,431,667.10	1,542,451,761.14
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	33,000,000.00	34,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	33,000,000.00	34,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,565,341,064.83	852,594,273.94
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,209,050,000.00	610,669,940.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	356,291,064.83	241,924,333.94
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	677,090,602.27	655,857,487.20
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (3)=(1)-(2)	10,569,400.00	166,362,915.00
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн (4)	-	-
5	Хөрөнгө оруулалтын зардлын дүн (5)	10,569,400.00	166,362,915.00

22	Хөрөнгийн зардал	10,569,400.00	166,362,915.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,569,400.00	166,362,915.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,569,400.00	166,362,915.00
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (6)=(4)-(5)	(10,569,400.00)	(166,362,915.00)
	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	=	=
7	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	=	=
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ(8)=(3)+(6)+(7)	=	=
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	=	=
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	=	=

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 01-ний үлдэгдэл	44,964,769.50	1,290,344.75	1,104,065,665.00	1,150,320,779.25
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,964,769.50	1,290,344.75	1,104,065,665.00	1,150,320,779.25
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	39,337,589.09	39,337,589.09
C08	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	44,964,769.50	1,290,344.75	1,143,403,254.09	1,189,658,368.34
D01	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	44,964,769.50	1,290,344.75	1,143,403,254.09	1,189,658,368.34
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,964,769.50	1,290,344.75	1,143,403,254.09	1,189,658,368.34
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(338,668,990.28)	(338,668,990.28)
D09	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	44,964,769.50	1,290,344.75	804,734,263.81	850,989,378.06

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	6,135,456,900.00	6,087,971,965.90	47,484,934.10	99.2
21	Урсгал зардал	6,135,456,900.00	6,087,971,965.90	47,484,934.10	99.2
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	5,849,456,900.00	5,802,377,691.96	47,079,208.04	99.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл	1,294,194,100.00	1,273,174,781.84	21,019,318.16	98.4
210101	Үндсэн цалин	681,235,300.00	731,403,024.19	(50,167,724.19)	107.4
210102	Нэмэгдэл	184,791,400.00	190,979,993.82	(6,188,593.82)	103.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	226,200,000.00	218,729,658.44	7,470,341.56	96.7
210104	Урамшуулал	173,445,600.00	70,774,295.36	102,671,304.64	40.8
210105	Гэрээт ажлын хөлс	28,521,800.00	61,287,810.03	(32,766,010.03)	214.9
2102	АО-с нийгмийн даатгалын шимтгэл	182,208,700.00	160,877,668.99	21,331,031.01	88.3
210201	Тэтгэврийн даатгал	141,717,900.00	124,331,956.30	17,385,943.70	87.7
210202	Тэтгэмжийн даатгал	13,496,900.00	12,609,092.73	887,807.27	93.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,699,400.00	3,171,025.39	(471,625.39)	117.5
210204	Ажилгүйдлийн даатгал	10,797,500.00	8,562,714.74	2,234,785.26	79.3
210205	Эрүүл мэндийн даатгал	13,497,000.00	12,202,879.83	1,294,120.17	90.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,500,000.00	23,933,445.00	566,555.00	97.7
210304	Байрны түрээс	24,500,000.00	23,933,445.00	566,555.00	97.7
2104	Хангамж, бараа материалын зардал	206,500,000.00	205,702,482.26	797,517.74	99.6
210401	Бичиг хэрэг	27,500,000.00	27,436,660.00	63,340.00	99.8
210402	Тээвэр, шатахуун	12,000,000.00	12,000,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,500,000.00	4,170,172.26	329,827.74	92.7
210404	Ном, хэвлэл	146,000,000.00	145,679,330.00	320,670.00	99.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд	16,500,000.00	16,416,320.00	83,680.00	99.5

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	164,500,000.00	163,946,500.00	553,500.00	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	154,500,000.00	154,257,700.00	242,300.00	99.8
210602	Тавилга	1,000,000.00	990,000.00	10,000.00	99.0
210604	Урсгал засвар	9,000,000.00	8,698,800.00	301,200.00	96.7
2107	Томилолт, зочны зардал	545,500,000.00	544,834,541.87	665,458.13	99.9
210701	Гадаад албан томилолт	425,000,000.00	424,692,448.87	307,551.13	99.9
210702	Дотоод албан томилолт	27,000,000.00	26,686,000.00	314,000.00	98.8
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	93,500,000.00	93,456,093.00	43,907.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	3,082,454,100.00	3,081,116,352.00	1,337,748.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	3,079,468,100.00	3,078,872,742.00	595,358.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,471,110.00	28,890.00	98.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	426,000.00		426,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	772,500.00	227,500.00	77.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	349,600,000.00	348,791,920.00	808,080.00	99.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	289,100,000.00	288,291,920.00	808,080.00	99.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	60,500,000.00	60,500,000.00		100.0
213	Урсгал шилжүүлэг	286,000,000.00	285,594,273.94	405,726.06	99.9
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	34,000,000.00	34,000,000.00		100.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	34,000,000.00	34,000,000.00		100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	252,000,000.00	251,594,273.94	405,726.06	99.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж	10,000,000.00	9,669,940.00	330,060.00	96.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал	242,000,000.00	241,924,333.94	75,666.06	100.0
	Зардлыг санхүүжүүлэх эх, үүсвэр	6,135,456,900.00	6,087,971,965.90	47,484,934.10	99.2
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	6,135,456,900.00	6,083,120,965.90	52,335,934.10	99.1
132001	Орон нутгийн төсвөөс	6,135,456,900.00	6,083,120,965.90	52,335,934.10	99.1
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		4,851,000.00	(4,851,000.00)	-
6	Төсвийн бусад мэдээллийн ангилал				
61	Байгууллагын тоо	1	1		100.0
610001	Төсвийн байгууллага	1	1		100.0
62	Ажиллагсдын тоо	54	48	6	88.8
620001	Удирдах ажилтан	7	7	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	47	41	6	87.2
65	Орон тооны мэдээлэл	54	48	6	88.8
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	9	2	81.8
650009	Т бусад албан хаагч (ТҮ)	13	11	3	84.6
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	29	28	1	96.5

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Данс	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,408,981,202.80
21	Урсгал зардал	1,408,981,202.80
210	Бараа,ажил үйлчилгээний зардал	807,981,202.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	788,836,702.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	788,836,702.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,144,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,144,500.00
213	Урсгал шилжүүлэг	601,000,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	601,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	601,000,000.00
II	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,064,838,690.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,064,838,690.00
131104	Дээд шатны ТЗ-ийн төсвөөс доод шатны ТЗ-д хуваарилсан хөрөнгө	790,500,000.00
131105	ТБ-ын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	654,902,290.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	619,436,400.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	619,436,400.00
IV	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ(III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 622,436.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав.

Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		(мянган төгрөг)			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүжилтийг дутуу бүртгэж, тайлагнасан.	1	619,436.4	1	619,436.4			1	619,436.4		
Үр дүнгийн тайланд зардлыг илүү бүртгэж тайлагнасан.	1	3,000.0			1	3,000.0	1	3,000.0		
Дүн	1	622,436.4	1	619,436.4	1	3,000.0	1	622,436.4		

Аудитаар нийт 47,558.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 8,638.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 38,920.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		(мянган төгрөг)					
			Үүнээс:					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд анхан шатны баримтгүй гадаад томилолтын ажил гүйлгээг зардлаар бүртгэж тайлагнасан	1	8,638.1	1	8638.1				
Тайлант онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын хамтарсан багийн төслийн хэрэгжилт, санхүүгийн баримтын бүрдэл хүчин төгөлдөр нотлох баримтаар баталгаажаагүй, төслийн хэрэгжилтэд хяналтыг хэрэгжүүлээгүй.	1	5,000.0					1	5,000.0
Тайлант онд зохион байгуулагдсан 3 төсөл арга хэмжээний анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох дэмжих баримт хангалтгүй.	1	33,920.0					1	33,920.0
Дүн	3	47,558.1	1	8,638.1			2	38,920.0

АДБОУС 4000-16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аль стандарт дагаж мөрдөхийг үнэлэх нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Шилэн дансны болон бусад хууль тогтоомжийн заалтад нийцээгүй зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд								
Тайлант онд намын суудлын санхүүжилтийг олгож зардлаар бүртгэж тайлагнасан.	1	34,000.0					1	34,000.0
Дүн	1	34,000.0					1	34,000.0
Шилэн дансны аудитаар								
Шилэн дансанд зардлын 203,722.9 мянган төгрөгийн 9 ажил гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан.	1	203,722.9					1	203,722.9
Дүн	1	203,722.9					1	203,722.9